



I-II/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13



Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 26.9 хувиар өслөө

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 2 сард 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 923.3 (26.9%) тэрбум төгрөгөөр өслөө.

Үүнд хүнсний бүтээгдэхүүн, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 2 дугаар сард 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 424.1 (17.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО¹, жил бүрийн эхний 2 сарын байдлаар

	2020		2021		2022*		2022* I-II
	II	I-II	II	I-II	II	I-II	2021 I-II
	тэрбум төгрөг						хувь
Нийт	1 453.0	3 049.0	1 662.4	3 428.8	1 964.0	4 352.1	126.9
Бөөний худалдаа	530.6	1 145.1	636.0	1 360.9	781.6	1 741.6	128.0
Жижиглэн худалдаа	922.4	1 903.9	1 026.5	2 067.9	1 182.4	2 610.5	126.2

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо


Худалдааны салбарын 2022 оны эхний 2 сарын борлуулалтын орлогын 40.0 хувь нь бөөний худалдаа, 60.0 хувь жижиглэн жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2022 оны эхний 2 сард 2.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 542.6 (26.2%) тэрбум төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 1.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 380.8 (28.0%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 83.7 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 2 сард 3.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 807.5 (28.5%) тэрбум төгрөгөөр өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлого Дорноговь, Өмнөговь аймагт 2022 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 4.5-25.7 хувиар буурсан байна. Харин бусад аймгуудад 5.6-78.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, жил бүрийн эхний 2 сарын байдлаар, аймгаар, тэрбум төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс орсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс орсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн
 газрын дарга А.Дэмбэрэл
 Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
 газрын статистикч Л.Энхбаатар
 Утас: (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212